

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН-ГАДААД ХАРИЛЦААНЫ  
САЙДАД НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААР АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2016 оны 07 дугаар  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын  
гишүүн Ж.Энхбаяр**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат Засгийн газрын гишүүн-Гадаад харилцааны сайдаар Цэндийн Мөнх-Оргилыг томилуулах саналыг 2016 оны 07 дугаар сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.6 дахь хэсэгт заасныг баримтлан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2016 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Засгийн газрын гишүүн-Гадаад харилцааны сайдад нэр дэвшигч Цэндийн Мөнх-Оргил нь 1988 онд Москвагийн Олон улсын харилцааны дээд сургууль, 1996 онд Харвардын их сургуулийн Хуулийн сургуулийг тус тус төгссөн. Хуульч мэргэжилтэй.

Ц.Мөнх-Оргил нь 1988-1991 онд Гадаад явдлын яаманд түшээ, 1991-1995 онд Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суух Байнгын төлөөлөгчийн газарт атташе, 1997-1998 онд Америкийн Нэгдсэн Улсын Вашингтон хотын Хуулийн пүүст хуульч, 1998-2000 онд "Мөнх-Оргил, Идэш, Линч" ХХК-ийн гүйцэтгэх захирал, 2000-2004 онд Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд, 2004-2012 онд Улсын Их Хурлын гишүүн, 2004-2006 онд Засгийн газрын гишүүн, Гадаад хэргийн сайд, 2007-2008 онд Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд, 2006-2007 онд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны даргаар тус тус ажиллаж байсан. 2016 оны 6 дугаар сараас Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байна.

Байнгын хорооны хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүн Ц.Цогзолмаа гадаад харилцааны агуулгыг эдийн засагжуулах шинэ бодлого, менежментийг гаргаж ирэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах чиглэлд идэвхи санаачлагатай ажиллах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр гадаад харилцааны салбарын чиглэлээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг судлан, хууль, эрх зүйн шинэчлэлд анхаарч ажиллах нь зүйтэй гэсэн саналыг тус тус хэллээ.


Цэндийн Мөнх-Оргилыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гадаад харилцааны сайдаар томилуулах тухай Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын саналыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гадаад харилцааны сайдаар Цэндийн Мөнх-Оргилыг томилуулах саналын талаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Ж.ЭНХБАЯР